



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/821

Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Тохижилт үйлчилгээний анги (РД:3186024)-д Булган сумын 1 дүгээр баг Л.Энэбиш 1 дүгээр гудамж 120а тоотод байршилтай 4327323 төлөвлөлтийн дугаартай 33932 м2, Булган сумын 1 дүгээр баг Л.Энэбиш 2 дугаар гудамж 200а тоотод байршилтай 4327322 төлөвлөлтийн дугаартай 28986 м2 газрыг тус тус нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбайн зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Булган аймгийн Тохижилт үйлчилгээний анги (Ц.Даваадорж)-тай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг аймгийн Тохижилт үйлчилгээний анги (Ц.Даваадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

